

No. 45190*

—
**Austria
and
Mongolia**

Agreement between the Republic of Austria and Mongolia on the mutual recognition of equivalences in higher education. Vienna, 31 March 2006

Entry into force: *1 June 2008 by notification, in accordance with article 8*

Authentic texts: *German and Mongolian*

Registration with the Secretariat of the United Nations: *Austria, 18 August 2008*

—
**Autriche
et
Mongolie**

Accord entre la République d'Autriche et la Mongolie relative à la reconnaissance mutuelle des équivalences dans le domaine de l'enseignement supérieur. Vienne, 31 mars 2006

Entrée en vigueur : *1er juin 2008 par notification, conformément à l'article 8*

Textes authentiques : *allemand et mongol*

Enregistrement auprès du Secrétariat des Nations Unies : *Autriche, 18 août 2008*

* *The texts reproduced below are the original texts of the agreement as submitted. For ease of reference, they were sequentially paginated. The relevant Treaty Series volume will be published in due course.*

Les textes reproduit ci-dessous sont les textes authentiques de l'accord tel que soumises pour l'enregistrement. Pour référence, ils ont été présentés sous forme de la pagination consécutive. Le volume correspondant du Recueil des Traités sera disponible en temps utile.

[MONGOLIAN TEXT – TEXTE MONGOL]

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН ИЖИЛ ТЭНЦҮҮ БАЙДЛЫГ ХАРИЛЦАН
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД
НАЙРАМДАХ АВСТРИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНЦДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар
/цаашид Хэлэлцэн тохирогч талууд гэнэ/.

Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа болон дээд боловсролын
салбар дахь харилцан солилцоог дэмжихийг эрмэлзэн,

Тухайн улсын их, дээд сургуульд элсэн орох эсвэл сургалтаа үргэлжлүүлэх
асуудлыг хоёр орны суралцагчдад хөнгөвчлөхийг эрмэлзэн,

Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын чиглэлээр хамтын
ажиллагааг дэмжихийг эрмэлзэн,

Европын Болондын процессыг сонирхон ажиглахыг эрмэлзэн,

Дээд боловсролын шатанд сургалтыг үргэлжлүүлэх эсхүл дараах шатны
сургалтад хамрагдуулах зорилгоор сургалтын ба шалгалтын үзүүлэлтүүдийг
хүлээн зөвшөөрөх болон дээд боловсролын зэргийг хэрэглэх талаар

Дараах зүйлийг хэлэлцэн тохиров.

1 дүгээр зүйл

Хэлэлцээрийн зорилго

1. Энэхүү хэлэлцээрийн зорилго нь Хэлэлцэн тохирогч талуудын дээд
боловсролын байгууллагуудаас олгож буй Хэлэлцэн тохирогч талуудын
суралцагчдын эзэмшсэн боловсролын баримт бичиг, гэрчилгээ, төгсөлтийг хүлээн
зөвшөөрөх асуудлыг хөнгөвчлөхөд оршино. Энэхүү хэлэлцээр нь Талуудын
өөрсдийн хууль тогтоомжийн дагуу дээрхи асуудлыг хүлээн зөвшөөрөх тухай
шийдвэрийг гаргах эрх бүхий байгууллагуудад зориулсан зөвлөмжүүдийг агуулна.

2. Хэлэлцэн тохирогч талуудын холбогдох хуулийн дагуу тогтоосон бүхий л
журмуудыг үл хөндөнө.

2 дугаар зүйл

Хэлэлцээрийн үйлчлэх хүрээ

1. Энэхүү хэлэлцээрт "дээд боловсролын байгууллага" гэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно.

1.1 Бүгд Найрамдах Австри Улсын хувьд бүх улсын болон улсаас хүлээн зөвшөөрсөн их сургуулиуд, мэргэжлийн дээд сургуулийн байгууллагууд болон хувийн их сургуулиуд.

1.2 Монгол Улсын хувьд бүх магадлан итгэмжлэгдсэн төрийн болон хувийн их, дээд сургуулиуд.

2. Хэлэлцэн тохирогч талууд энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан дээд боловсролын байгууллагуудын нэрсийн жагсаалтуудыг харилцан өөнийлцөж мэдээлж байна.. Уг жагсаалтууд нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болохгүй.

3. Энэхүү хэлэлцээр нь доод тал нь 12 жилийн сургалттай ерөнхий боловсролын дунд сургуулийн гэрчилгээ эсвэл түүнтэй адилтгах баримт бичгийг үндэслэн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт явуулдаг уг зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан дээд боловсролын байгууллагуудад үйлчилнэ.

3 дугаар зүйл

Сургалтын кредит болон шалгалтын үзүүлэлтийг хүлээн зөвшөөрөх

1. Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын кредит болон шалгалтын үзүүлэлтийг холбогдох сургалтын хөтөлбөрийн шаардлага болон суралцахыг хүсэгчийн дүүргэсэн сургалтын кредит болон, шалгалтын үзүүлэлтийг батлах баримт бичгийн үндсэн дээр харилцан хүлээн зөвшөөрнө.

2. Дээрхи заалтын дагуу уг үзүүлэлтүүдийг харьцуулах явцад зөрүү гарвал энэхүү дутаж буй үзүүлэлтийг элсэн орж буй тухайн сургуульдаа нөхөж гүйцээх боломжийг суралцахыг хүсэгчид олгоно.

4 дүгээр зүйл

Магистрын эсхүл Мастерийн сургалтад хамрагдах

1. Энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан Монгол Улсын дээд боловсролын байгууллагаас олгогдсон бакалаврын зэрэг эзэмшигч нь Австри Улсад магистрын буюу түүнтэй адилтгах түвшний сургалтад хамрагдаж болно. Хүлээн зөвшөөрөх болон элсүүлж түвшин тогтоох асуудлыг тухайн сургууль өөрийн сургалтын хөтөлбөрийн үндсэн дээр шийдвэрлэнэ.

2. Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан Австри Улсын дээд боловсролын байгууллагаас олгогдсон бакалаврын зэрэг эзэмшигч, эсхүл 2 дугаар зүйлд заасан Австри Улсын дээд боловсролын байгууллагад доод тал нь 6 семестр бүхий дипломын сургалтад хамрагдаж буй суралцагч Монгол Улс дахь магистрын

сургалтад хамрагдаж болно. Хүлээн зөвшөөрөх болон элсүүлж түвшин тогтоох асуудлыг тухайн сургууль өөрийн сургалтын хөтөлбөрийн үндсэн дээр шийдвэрлэнэ.

5 дугаар зүйл

Докторын сургалтад хамрагдах

1. Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан Монгол Улсын дээд боловсролын байгууллагаас олгогдсон магистрын зэрэг эзэмшигч нь Австри Улсад докторын сургалтад хамрагдаж болно. Хүлээн зөвшөөрөх болон элсүүлж түвшин тогтоох асуудлыг тухайн сургууль өөрийн сургалтын хөтөлбөрийн үндсэн дээр шийдвэрлэнэ.

2. Мөн 2 дугаар зүйлд заасан Австрийн дээд боловсролын байгууллагын магистрын зэрэг эзэмшигч болон дипломын сургалтыг төгсөгч нь Монгол Улсад сургалтад хамрагдаж болно. Хүлээн зөвшөөрөх болон элсүүлж түвшин тогтоох асуудлыг тухайн сургууль өөрийн сургалтын хөтөлбөрийн үндсэн дээр шийдвэрлэнэ.

3. Ийнхүү хүлээн зөвшөөрөх нь нэмэлт зүйлээс (нэмэлт шалгалт болон/эсвэл эрдэм шинжилгээний бичгийн ажил) хамаарч болно.

6 дугаар зүйл

Эрдмийн зэрэг хэрэглэх

1. 2 дугаар зүйлд заасан Монгол Улсын дээд боловсролын байгууллагаас олгогдсон :

- Бакалавр,
- Магистр,
- Докторын

зэрэг эзэмшигч нь Бүгд Найрамдах Австри Улсад энэхүү эрдмийн зэргээ англи хэл дээр нэрийнхээ дараа бичиж хэрэглэж болно.

2. Мөн 2 дугаар зүйлд заасан Австрийн дээд боловсролын байгууллагаас олгогдсон :

- Дипломын зэрэг,
- Бакалавр,
- Магистр,
- Мастер,
- Докторын

зэрэг эзэмшигч нь Монгол Улсад Бүгд Найрамдах Австри Улсад олгогдсон хэлбэрээр нь энэхүү эрдмийн зэргээ хэрэглэж болно.

13./ Хэлэлцэн тохирогч талууд холбогдох дээд боловсролын зэргийн жагсаалтыг гаргаж, харилцан мэдээлж байна. Уг жагсаалт нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болохгүй.

7 дугаар зүйл

Мэргэжлийн байнгын комисс

11./ Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилттэй холбоотой бүх асуудлаар зөвлөлдөх үүднээс мэргэжлийн байнгын комисс томилогдон ажиллана. Комиссын бүрэлдэхүүнийг хэлэлцэгч талууд тус бүр 3 хүртэлх гишүүн томилон бүрдүүлнэ. Гишүүдийн нэрсийн жагсаалтыг дипломат шугамаар солилцоно.

12./ Мэргэжлийн байнгын комисс нь шаардлагатай тохиолдолд Хэлэлцэн тохирогч аль нэг талын хүсэлтээр хуралдана. Хуралдаан хийх газрыг дипломат шугамаар тохирно.

8 дугаар зүйл

Үйлчлэх хугацаа болон хүчин төгөлдөр болох

Энэхүү хэлэлцээр нь тодорхой бус хугацаагаар байгуулагдана. Хэлэлцэн тохирогч тал бүр хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын шаардлагыг биелүүлсэн тухай дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 3 дахь сарын эхний өдрөөс эхлэн энэхүү хэлэлцээр нь хүчин төгөлдөр болно.

Хэлэлцэн тохирогч аль нэг тал энэхүү хэлэлцээрийг цуцлах талаар нөгөө талдаа дипломат шугамаар бичгээр мэдэгдэж болно. Аль нэг тал нь энэ тухай мэдэгдлийг бичгээр хүлээн авснаас хойш 6 сарын дараа тус хэлэлцээр хүчингүй болно.

Энэхүү хэлэлцээрт эрх бүхий этгээдүүд гарын үсгээ зурж, битүүмжилнэ.

Энэхүү хэлэлцээрийг 2006 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Вена хотноо монгол, герман хэл дээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД
ӨЛЗИЙСАЙХАНЫ ЭНХТҮВШИН

ХОЛБООНЫ БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СОЁЛЫН САЙД
ЭЛИЗАВЕТ ГЭЭРЭР